



**“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” –НЫ 2015 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТОВЧ АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Танилцуулга
- 1.2 Бүтэц, орон тоо

ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1 Мэдээллийн сангийн чиглэлээр
 - 2.1.1 Жолоочийн даатгалын гэрээ, хураамжийн орлого
 - 2.1.2 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр
 - 2.1.3 Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа
 - 2.1.4 Даатгалын зуучлагч компани
 - 2.1.5 Мэдээллийн сангаас олгосон лавлагаа
- 2.2 Даатгалын сангийн чиглэлээр
 - 2.2.1 Даатгалын сангийн орлого төвлөрүүлэлтийн хүрээнд
 - 2.2.2 Даатгалын сангийн нөхөн төлбөр олголтын хүрээнд
 - 2.1.4 Сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлын хүрээнд
- 2.3 Шуурхай албаны чиглэлээр
 - 2.3.1 Даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч шийдвэрлэсэн байдал
 - 2.3.2 Хамтарсан хяналт шалгалт, түүний үр дүн

ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1 Захиргаа, хүний нөөцийн ажлын хүрээнд
- 3.2 Дүрэм, журам, заавар боловсронгуй болгох ажлын хүрээнд
- 3.3 Холбооны 2015 оны төсвийн гүйцэтгэл

ДӨРӨВ. САНАЛ ДҮГНЭЛТ

- 4.1 Даатгалын сангийн чиглэлээр
- 4.2 Мэдээллийн сангийн чиглэлээр
- 4.3 Шуурхай албаны чиглэлээр

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Танилцуулга

Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 10 сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 сарын 02-ны өдрийн 301 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, мөн оны 11 сарын 07-ны өдөр үүсгэн байгуулж улсын бүртгэлийн гэрчилгээ авснааср Албан журмын даатгагчдын холбоо үүсгэн байгуулагдаж байсан.

Холбоо нь Жолоочийн даатгалын санг бүрдүүлэх, нөхөн төлбөр олгох, даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагаа, уялдаа холбоог ханган зохион байгуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сурталчилгаа хийх, даатгагч, даатгуулагч, хохирогчийн эрхийг хамгаалах үүрэгтэй ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

2015 онд Холбоо нь Удирдах зөвлөлийн 2013 оны 12 сарын 26-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан “Албан журмын даатгагчдын холбооны 2014-2016 оны хөгжлийн стратеги төлөвлөгөө”, АЖДХ-ны 2015 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Холбооны дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаа.

1.2 Холбооны бүтэц, орон тоо


Холбоо нь Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Зам, тээврийн яам, Замын цагдаагийн газар, даатгагчдын болон зуучлагчдын төлөөлөл бүхий хорооноос томилсон 9 гишүүнээс бүрдсэн удирдах зөвлөлийн гишүүдтэй ба уг зөвлөл нь Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, даатгуулагч, даатгагч, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны явцад хяналт тавих үүрэгтэй.

Холбооны Удирдах зөвлөл тайлант хугацаанд 9 удаагийн, 65,9 хувийн дундаж ирцтэйгээр хуралдаж, нийт 29 асуудал хэлэлцэн 22 тогтоол, тэмдэглэлээр 23 шийдвэр гаргасан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанд 2 асуудал оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг хуульд заасан чиг үүргийн дагуу зохион байгуулах Ажлын албатай ба үүнийг Удирдах зөвлөлөөс томилсон Гүйцэтгэх захирал удирлагаар ханган ажиллаж байна. Удирдах зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар тогтоолоор ажлын албаны бүтэц орон тоог 4 нэгж, 25 орон тоотойгоор, орон нутаг дахь салбарыг 32 орон тоотойгоор шинэчлэн тогтоосон.

Ажлын албаны чиг үүргийн хүрээнд Захиргаа, санхүүгийн нэгж, Даатгалын сан, Мэдээллийн сан, Шуурхай алба болон 21 аймагт өөрийн салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР



2.1.1 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУРААМЖИЙН ОРЛОГО

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компани 2015 онд 524256 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 22,418,521,903 төгрөгийн даатгалын хураамжийн орлого 2016 оны 3 дугаар сарын 16-ны байдлаар олсон байна.

Даатгалын гэрээг ангиллын хувьд авч үзвэл хувь хүний 406572, хуулийн этгээдийн 98506, мэргэшсэн болон C D ангиллын жолоочийн 15267, дамжин өнгөрөхийн 3911 гэрээ байгуулагдсан байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүнгийн хэмжээг Хүснэгт 1 - ээс харна уу.

Хүснэгт 1. Жолоочийн даатгалын гэрээ, хураамжийн дүн /Даатгалын компани болон гэрээний ангиллаар/

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, CD		Дамжин өнгөрөх		Нийт гэрээн ий тоо	Нийт хураамжийн дүн
		Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
1	Соёмбо даатгал	12239	415,638,680	4111	344,628,052	702	21,755,576	31	2,833,930	17083	784,856,238
2	Миг даатгал	73643	2,570,678,532	16016	1,085,746,644	2546	83,751,181	50	3,798,682	92255	3,743,975,039
3	Мөнх даатгал	761	20,128,869	629	43,307,900	239	7,444,305	1594	128,818,925	3223	199,699,999
4	Монгол даатгал	70305	2,436,434,361	16747	1,345,904,477	3323	107,519,519	843	37,887,211	91218	3,927,745,568
5	Практикал даатгал	27377	909,071,894	7019	544,951,856	909	29,228,425	298	14,415,309	35603	1,497,667,484
6	Гэр даатгал	984	34,456,675	382	25,885,785	25	752,235	0	0	1391	61,094,695
7	Улаанбаатар хотын даатгал	55	2,377,259	132	10,537,492	0	0	0	0	187	12,914,751
8	Номин даатгал	24168	852,735,082	4402	347,250,555	840	27,740,786	4	348,892	29414	1,228,075,315
9	Тэнгэр даатгал	27600	975,558,940	8930	683,537,552	1160	37,500,945	16	1,589,835	37706	1,698,187,272
10	Бодь даатгал	67799	2,438,199,438	11831	867,417,893	1464	44,138,484	737	36,308,461	81831	3,386,064,276
11	Ган зам даатгал	101	4,085,395	181	12,256,215	81	2,550,900	0	0	363	18,892,510
12	Монре даатгал	29666	1,059,283,194	7499	520,926,165	727	22,427,771	3	67,900	37895	1,602,705,030
13	Ард даатгал	38443	1,315,927,901	9617	690,892,484	1545	51,131,518	110	5,338,625	49715	2,063,290,528
14	Мандал даатгал	23004	976,774,218	8823	639,946,513	1265	41,154,913	148	6,896,701	33240	1,664,772,345
15	Хаан даатгал	10427	349,833,811	2187	161,456,400	441	13,674,042	77	3,616,600	13132	528,580,853
Нийт дүн		406572	14,361,184,249	98506	7,324,645,983	15267	490,770,600	3911	241,921,071	524256	22,418,521,903

График 1. Жолоочийн даатгалын гэрээ /Даатгалын компаниар/.**График 2.** Жолоочийн даатгалын гэрээний хураамжийн харьцаа /Гэрээний ангиллаар/

Жолоочийн даатгалын гэрээг газар нутгийн байршлаар гэрээний тоо, хураамжийн хэмжээг Хүснэгт 2-с харна уу.

Хүснэгт 2. Жолоочийн даатгалын гэрээ /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Говьсүмбэр	2,332	88,997,693
2	Говь-Алтай	6,329	195,234,089
3	Дундговь	6,514	189,791,707
4	Завхан	6,824	220,802,315
5	Ховд	7,017	237,911,249
6	Булган	7,277	224,118,987
7	Баян-Өлгий	7,394	224,742,596
8	Увс	7,701	238,645,511
9	Архангай	7,786	244,617,932
10	Сүхбаатар	8,222	245,580,242
11	Дорнод	8,451	264,709,668
12	Баянхонгор	8,918	273,919,589
13	Хэнтий	8,923	278,519,965
14	Дорноговь	8,925	320,563,738
15	Төв	10,903	352,710,701
16	Хөвсгөл	12,242	383,271,108
17	Сэлэнгэ	12,571	434,683,927
18	Дархан-Уул	12,589	491,052,465
19	Өвөрхангай	12,793	392,398,269
20	Өмнөговь	14,360	792,256,480
21	Орхон	16,253	628,154,001
22	Улаанбаатар	326,056	15,456,108,010
	Нийт	520,380	22,178,790,242

2015 онд жолоочийн даатгалд хамрагдалтыг өмнөх 2014 оны мөн үеийн жолоочийн даатгалын тоо мэдээтэй харьцуулж харуулбал:

Хүснэгт 8. Жолоочийн даатгалд хамрагдалт /Өмнөх онтой харьцуулахад/

Д/д	Үзүүлэлт	2014.12.31	2015.12.31
1	Даатгалын гэрээний тоо	499,856	524,256
2	Даатгалын хураамж /төг/	19,345,095,596	22,418,521,903
3	Нөхөн төлбөр авсан тоо	23,089	30,909
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	11,436,191,402	14,479,900,289
Жолоочийн даатгалд хамрагдалт			4,9% хувиар өсөв

2.1.2 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компаниас 2015 онд 30909 жолоочийн даатгалын тохиолдолд 14,479,900,289 төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрийн хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан 29916 даатгалын тохиолдолд 13,480,107,990 төгрөгийн нөхөн төлбөр, эд хөрөнгөд хохирол учруулсан 550 даатгалын тохиолдолд 451,190,880 төгрөгийн нөхөн төлбөр, 443 бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан даатгалын тохиолдолд 548,601,419 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг Хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 3. Нөхөн төлбөр /Даатгалын компани, эрсдлийн ангиллаар/

№	Даатгагч	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн
		Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн		
1	Соёмбо даатгал	698	364,562,267	13	10,326,481	3	19,023,000	8	12,122,133	722	406,033,881
2	Миг даатгал	5,298	1,355,560,838	141	100,405,800	10	28,225,786	87	62,071,788	5,536	2,546,264,212
3	Мөнх даатгал	23	18,218,720	1	571,662	0	0	0	0	24	18,790,382
4	Монгол даатгал	5,019	1,250,219,864	74	74,005,613	15	48,802,084	112	106,640,597	5,220	2,479,668,158
5	Практикал даатгал	1,598	750,207,140	31	31,927,279	7	26,019,535	24	24,090,968	1,660	832,244,922
6	Гэр даатгал	93	45,514,710	0	0	0	0	2	635,600	95	46,150,310
7	Улаанбаатар хотын даатгал	7	2,616,200	0	0	0	0	0	0	7	2,616,200
8	Номин даатгал	1,943	829,034,168	36	33,267,528	5	9,739,000	17	10,480,919	2,001	882,521,615
9	Тэнгэр даатгал	2,181	1,015,075,679	28	28,374,214	3	15,000,000	25	26,423,081	2,237	1,084,872,974
10	Бодь даатгал	5,211	1,035,631,578	53	39,738,289	15	50,469,232	87	59,990,496	5,366	2,185,829,595
11	Ган зам даатгал	53	27,030,895	0	0	0	0	0	0	53	27,030,895
12	Монре даатгал	2,268	1,051,301,976	33	38,355,365	0	0	0	0	2,301	1,089,657,341
13	Ард даатгал	2,593	1,557,609,481	27	35,166,123	7	25,480,400	6	9,042,900	2,633	1,627,298,904
15	Мандал даатгал	2,423	849,796,117	104	46,307,861	0	0	0	0	2,527	896,103,978
16	Хаан даатгал	460	218,433,123	8	9,452,525	2	4,623,739	7	8,323,031	477	240,832,418
17	АЖДХ	48	109,295,234	1	3,292,140	0	0	1	1,397,130	50	113,984,504
Нийт дүн		29,916	13,480,107,990	550	451,190,880	67	227,382,776	376	321,218,643	30,909	14,479,900,289

График 3. Нөхөн төлбөрийн дүн, даатгалын компаниар /мянган төгрөг/**Хүснэгт 4.** Нөхөн төлбөр /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Завхан	32	18,270,629
2	Баянхонгор	38	27,251,095
3	Ховд	40	21,263,544
4	Архангай	43	31,223,092
5	Говь-Алтай	49	22,880,047
6	Дундговь	54	56,692,137
7	Булган	54	48,258,053
8	Увс	56	34,476,874
9	Баян-Өлгий	57	21,700,396
10	Сүхбаатар	58	39,073,397
11	Говьсүмбэр	61	28,901,074
12	Хэнтий	81	64,301,716
13	Өвөрхангай	88	64,904,488
14	Хөвсгөл	90	45,766,153
15	Өмнөговь	102	56,111,988
16	Дорноговь	115	84,506,269
17	Дорнод	147	91,225,041
18	Төв	200	257,792,447
19	Сэлэнгэ	203	183,760,433
20	Дархан-Уул	388	230,821,131

21	Орхон	473	230,299,097
22	Улаанбаатар	28,480	12,820,421,188
	Нийт	30,909	14,479,900,289

2015 онд даатгалын тохиолдол болон нөхөн төлбөр олголтын хэмжээ 2014 онтой харьцуулахад 1.21 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2015 онд сарын хугацаанд дунджаар 2496 даатгалын тохиолдолд 1,137,727,914 төгрөгийн нөхөн төлбөр олгосон дүнтэй байна.

Нөхөн төлбөрийн тоог нөхөн төлбөрийн хэмжээний хувьд ангилан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

№	Нэрс	Нөхөн төлбөрийн тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	200,000 хүртэлх	13804	1,767,271,341
2	200,000-500,000 хүртэлх	12118	3,741,703,337
3	500,000-800,000 хүртэлх	3371	2,102,699,811
4	800,000-1,000,000 хүртэлх	1055	936,996,524
5	1,000,000-1,500,000 хүртэлх	1283	1,559,595,459
6	1,500,000-2,000,000 хүртэлх	580	997,066,364
7	2,000,000-3,000,000 хүртэлх	439	1,061,446,506
8	3,000,000-4,000,000 хүртэлх	222	760,470,201
9	4,000,000-5,000,000 хүртэлх	121	531,123,901
10	5,000,000-8,000,000 хүртэлх	172	887,767,052
11	8,000,000-10,000,000 хүртэлх	11	103,939,793
12	10,000,000	2	29,820,000
	Нийт дүн	33178	14,479,900,289

2015 онд нөхөн төлбөр олгогдсон 30909 даатгалын тохиолдолоос 14722 даатгалын тохиолдол нь 2014 онд байгуулагдсан гэрээнээс, 16187 даатгалын тохиолдол нь 2015 онд байгуулагдсан гэрээнд хамаарах нөхөн төлбөр байна.

Хүснэгт 6. Нөхөн төлбөр /Гэрээ байгуулагдсан оноор/

Д/д	Даатгалын гэрээ байгуулагдсан он	2015 оны даатгалын тохиолдлын тоо	2015 онд олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	2014 онд байгуулагдсан гэрээнээс	14,722	6,586,895,618
2	2015 онд байгуулагдсан гэрээнээс	16,187	7,893,004,671
	Нийт	30,909	14,479,900,289


2.1.3. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХАРЬЦАА

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 15 даатгалын компани 2015 онд жолоочийн даатгалын хураамжийн орлогоос 22,418,521,903 төгрөгийн хураамжийн орлого олж, 14,479,900,289 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хураамжийн орлогод нөхөн төлбөр 64,6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 7. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа

№	Нэрс	Нийт хураамжийн дүн /төг/	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн /төг/	Хураамжын орлогод нөхөн төлбөрийн эзлэх хувь
1	Соёмбо даатгал	784,856,238	406,033,881	51,7%
2	Миг даатгал	3,743,975,039	2,546,264,212	68,0%
3	Мөнх даатгал	199,699,999	18,790,382	9,4%
4	Монгол даатгал	3,927,745,568	2,479,668,158	63,1%
5	Практикал даатгал	1,497,667,484	832,244,922	55,6%
6	Гэр даатгал	61,094,695	46,150,310	75,5%
7	Улаанбаатар хотын даатгал	12,914,751	2,616,200	20,3%
8	Номин даатгал	1,228,075,315	882,521,615	71,9%
9	Тэнгэр даатгал	1,698,187,272	1,084,872,974	63,9%
10	Бодь даатгал	3,386,064,276	2,185,829,595	64,6%
11	Ган зам даатгал	18,892,510	27,030,895	143,1%
12	Монре даатгал	1,602,705,030	1,089,657,341	68,0%
13	Ард даатгал	2,063,290,528	1,627,298,904	78,9%
14	Мандал даатгал	1,664,772,345	896,103,978	53,8%
15	Хаан даатгал	528,580,853	240,832,418	45,6%
	Нийт дүн	22,418,521,903	14,365,915,785	64,1%

График 7. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа



2.1.3 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ КОМПАНИ

Жолоочийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 19 зуучлалын компани 2015 онд 166,720 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 6,859,400,195 төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон байна. Тухайн хугацааны нийт гэрээний тоонд эзлэх хувийг авч үзвэл 31,8% хувь байна. Үүнээс 7 банк даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр банкнууд нь 54,330 гэрээ байгуулж, 2,220,872,814 төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон байна.

Хүснэгт 9. Жолоочийн даатгалын гэрээ /Зууч компаниар/

Д/Д	Даатгалын зууч компани	Жолоочийн даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын гэрээний хураамж	Нийт гэрээний тоонд эзлэх хувь	Нийт гэрээний хураамжид эзлэх хувь
1	Сүрэг хараацай	39,306	1,676,111,155	7,5%	7,5%
2	Смарт брокерс	11,252	455,309,218	2,1%	2,0%
3	ХААН Банк	3,902	120,207,201	0,7%	0,5%
4	Лоялти Солюшн	14,767	614,989,445	2,8%	2,7%
5	Эрсдэлийн шийдэл	36,843	1,444,600,920	7,0%	6,4%
6	Ачит-Ундарга	273	14,976,248	0,1%	0,1%
7	Төрийн банк	12,770	426,240,956	2,4%	1,9%
8	Капитал банк	52	2,293,771	0,0%	0,0%
9	Монгол бичээч	2,509	97,760,285	0,5%	0,4%
10	Ариг банк	52	3,250,223	0,0%	0,0%

11	Дэвжих дэлгэрэх	1,611	72,283,413	0,3%	0,3%
12	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	36,180	1,605,320,890	6,9%	7,2%
13	ХАС банк	99	5,015,601	0,0%	0,0%
14	Мастер шийдэл	2,442	105,744,035	0,5%	0,5%
15	ХХБ	1,275	58,544,172	0,2%	0,3%
16	LBBrokerage ХХК	2,001	97,286,334	0,4%	0,4%
17	Соёмбо Ай Би	11	724,332	0,0%	0,0%
18	Си Эн Эн Икс	164	7,558,307	0,0%	0,0%
19	Цагаан гэрэлт	1,211	51,183,689	0,2%	0,2%
Нийт		166,720	6,859,400,195	31,8%	30,6%

2.1.4 МЭДЭЭЛЛИЙН САНГААС ОЛГОСОН ЛАВЛАГАА

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлах утсанд 2015 онд ирсэн дуудлага

Хүснэгт 12. Мэдээллийн сангийн утсанд ирсэн дуудлага

№	Дуудлагын утга	Тоо
1	Нөхөн төлбөрийн лавлагаа	1641
2	ДК ажилтны лавлагаа	84
3	Хууль тогтоомжийн лавлагаа	84
4	Даатгалын сангийн лавлагаа	128
5	Мэдээллийн сангийн лавлагаа	372
6	Даатгалын гэрээний лавлагаа	1057
7	Санал гомдол	44
8	АЖДХ ажилтны лавлагаа	27
9	Даатгалын компаний утасны дугаар, хаяг байршил	79
10	Бусад	93
НИЙТ		3609

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн лавлагааг цахим хэлбэрээр 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Холбооны гишүүн даатгалын компани болон зуучлагч компаниудад 1,658,631 даатгуулагч болон тээврийн хэрэгслийн мэдээллийг олгосон байна.

2.2 ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

2.2.1 ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ ХҮРЭЭНД

УИХ-аас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн 22.1-д заасны дагуу Жолоочийн даатгалын санг үндсэн 6 төрлийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр хуульчилсан. Хуулийн хүрээнд 2015 онд Даатгалын сан нь даатгалын сангийн орлого бүрдүүлж төвлөрүүлэх ажлыг бүх аймаг, нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэс, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 15 даатгалын компаниуд, хуулийг хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж жолоочийн даатгалын санд нийт **2,930,330,227** төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

Хүснэгт 13

д/д	Даатгалын сангийн орлогын төрөл	Орлогын дүн
1	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрөх орлого	447,310,983
2	Торгуулийн орлогын 50 хувийн орлого	3,936,000
3	Буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийн орлого	94,902,364
4	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийн орлого	1,696,184,980
5	Мэдээллийн санг ашиглуулсны төлбөрийн орлого	32,697,100
6	Менежментийн ба шуурхай албаны дуудлагын үйлчилгээний орлого	638,373,740
	Гишүүний татвар, элсэлтийн хураамж	15,000,000
	Зээл, тусламж, хандив, бусад орлого	1,925,060
Нийт дүн		2,930,330,227

Үүнээс:

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрөх орлого:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1, хөрөнгө төвлөрүүлэх тухай Сангийн сайд, СЗХ-ны даргын хамтарсан 2015 оны 05 сарын 12-ны өдрийн 142/119 тоот тушаалын дагуу Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлэх зөвшөөрөл бүхий 15 даатгагчаас 2014 оны жолоочийн хариуцлагын даатгалын орлогод тооцсон хураамжийн дүн болох 17,942,826,752 төгрөгийн 2.5 хувь 448,194,504 төгрөг төвлөрүүлэхээс **447,310,983** төгрөгийг төвлөрүүлсэн байна. Даатгалын компани тус бүрийн төвлөрүүлсэн байдлыг хүснэгт 14-д харуулав.

Хүснэгт 14

д/д	Даатгалын компани	Санд төвлөрүүлэх хөрөнгө /2.5%/	Санд төвлөрүүлсэн хөрөнгө
1	Ард даатгал ХХК	38,589,588.22	38,589,589.00
2	Бодь даатгал ХХК	80,668,536.53	80,668,536.52
3	Ганзам даатгал ХХК	544,793.15	544,793.15
4	Гэр даатгал ХХК	2,881,398.58	2,881,398.58
5	Мандал даатгал ХХК	8,984,578.64	8,984,578.64
6	Миг даатгал ХХК	52,266,811.19	52,266,811.00
7	Монгол даатгал ХХК	93,303,398.38	93,303,398.38
8	Моннис даатгал ХХК	883,521.94	-
9	Монре даатгал ХХК	24,351,850.41	24,351,850.40
10	Мөнх даатгал ХХК	3,517,716.60	3,517,716.60
11	Номин даатгал ХХК	39,947,293.09	39,947,293.08
12	Практикал даатгал ХХК	33,180,998.81	33,180,998.82
13	Соёмбо даатгал ХХК	29,694,851.34	29,694,851.34
14	Тэнгэр даатгал ХХК	29,153,212.79	29,153,212.78
15	УБ хотын даатгал ХХК	484,466.30	484,466.30
16	Хаан даатгал ХХК	9,741,488.87	9,741,488.87
Нийт дүн		448,194,504.83	447,310,983.46

Моннис даатгал ХХК нь 2014 оны 1 дүгээр улиралд татан буугдсан учир жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлээгүй бөгөөд Жолоочийн даатгал эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх орлого 883,521 төгрөгөөр тасалдсан болно.

Хуульд заасан торгуулийн орлогын 50 хувийн орлого:

АЖДХолбоо нь ЗЦГ, АТҮТ-тэй байгуулсан хамтран ажиллах тухай санамж бичгийн хүрээнд хамтарсан хяналт шалгалтыг бүх аймаг, нийслэлийн хэмжээнд явуулж Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлдэг. Энэ торгуулийн орлогын 50 хувь нь ЖДТ хуулийн 22.1.2-д заасны дагуу Жолоочийн даатгалын сангийн нэг эх үүсвэр болдог ба 2015 онд Хэнтий аймгаас 2,400,000 төгрөг, Баянхонгор аймгаас 1,152,000 төгрөг, Хөвсгөл аймгаас 384,000 төгрөг болон нийт **3,936,000** төгрөгийг торгуулийн орлого жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15

д/д	Аймаг	Торгуулийн орлогын 50 хувийн орлого
1	Баянхонгор	1,152,000 төг
2	Хөвсгөл	384,000 төг
3	Хэнтий	2,400,000 төг

4	Бусад аймаг	Байхгүй
	Нийт дүн	3,936,000 төг

Буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийн орлого:

Буруутай этгээдээс буцаан нэхэмжэлсэн нөхөн төлбөрийн **94.902.364** төгрөгийн орлогыг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн .

Хүснэгт 16

д/д	он	Нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх гэрээ хийсэн хүний тоо	Нөхөн төлбөрийг гэрээний дагуу буцаан төлсөн хүний тоо	Буцаан нэхэмжэлсэн нөхөн төлбөрийн орлогын дүн
1	2013	15	4	3,776,660
2	2014	60	35	51,955,640
3	2015	49	42	39,170,064
	Нийт дүн	124	81	94.902.364

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийн орлого:**Хүснэгт 17**

д/д	Аймаг	УИХ баталсан	ИТХ баталсан	2015 оны Гүйцэтгэл	Дутуу /мянгаар/	Хувь	СЯ-ны гүйцэтгэл
1	Архангай	19,350.00	19,350.00	19,350.00		100	22,259.21
2	Баян-Өлгий	25,000.00	25,000.00	17,500.00	7,500.00	69	25,479.19
3	Баянхонгор	29,500.00	31,500.00	29,000.00	2,500.00	92	31,161.55
4	Булган	23,900.00	23,900.00	21,900.00	2,000.00	92	22,135.61
5	Говь-Алтай	25,500.00	22,674.80	21,494.80	1,180.00	95	21,829.97
6	Дорноговь	58,520.00	58,520.00	58,520.00		100	50,989.91
7	Дорнод	29,250.00	29,250.00	21,937.50	7,312.00	75	32,290.92
8	Дундговь	15,500.00	15,500.00	15,500.00		100	17,558.84
9	Завхан	22,015.00	22,015.00	22,015.00		100	20,384.48
10	Өвөрхангай	31,000.00	31,000.00	31,000.00		100	39,100.84
11	Өмнөговь	166,080.00	112,000.00	102,300.00	9,700.00	64	155,117.57
12	Сүхбаатар	30,240.00	30,240.00	30,240.00		100	29,660.59
13	Сэлэнгэ	42,100.00	42,100.00	42,100.00		100	42,596.69
14	Төв	21,184.70	21,118.50	21,118.50		100	28,924.02
15	Увс	19,500.00	19,500.00	19,500.00		100	20,764.00
16	Ховд	30,000.00	30,000.00	30,000.00		100	32,977.43
17	Хөвсгөл	20,400.00	43,725.00	45,855.00	2,130.00	105	41,028.29
18	Хэнтий	17,000.00	26,476.58	26,476.58		100	26,680.57
19	Дархан -Уул	45,240.00	45,240.00	45,240.00		100	51,926.97
20	Улаанбаатар	1,670,000.00	2,257,370.00	1,001,637.60	1,255,732.40	44	2,006,580.90
21	Орхон	64,500.00	64,500.00	64,500.00		100	69,894.41

22	Говьсүмбэр	7,400.00	9,000.00	9,000.00		100	9,413.68
Нийт дүн		2,413,179.70	2,979,979.88	1,696,184.98	1.285.924.90	56	2,798,755.63

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4 дэх заалтын дагуу/АТБӨЯХАТ-ын 10 хувь /2015 онд нийт 2,979,979.880 төгрөгийн орлогыг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхээс 1.696.184.980 төгрөгийн орлого төвлөрч 56 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дорноговь, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд нь жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх орлогыг хуулийн дагуу ИТХ-аас баталсан дүнгээс давуулан тухайн жилийн АТБӨЯХАТ-ын 10 хувийн гүйцэтгэлээс тооцож биелүүлсэн байна.

Мэдээллийн санг ашиглуулсны төлбөрийн орлого:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.5 дахь заалтын дагуу 2015 онд бусдад мэдээллийн санг ашиглуулсны төлбөрийн орлого **32,697,100** төгрөгийг жолоочийн даатгалын санд төвлөрсөн байна.

Менежментийн орлого:

АЖДХ нь 2012 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш одоог хүртэл ”Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын ГУРАВ-ыг удирдлага болгон сонгон шалгаруулж Хаан банк, Төрийн банк, Голомт банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, ХАС банк зэрэг 5 арилжааны банкаар Жолоочийн даатгалын нөөц санг төвлөрүүлэх, нөхөн төлбөр олгох, буцаан нэхэмжлэх, сангийн үйл ажиллагааг тогтмол явуулах үйл ажиллагааны орлого болон зарлагын төлбөр тооцоог дамжуулан гүйцэтгэж ирсэн.

Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журмын 3.1-дэх хэсэг, Арилжааны банкуудын өрсөлдөөн, эдийн засгийн өнөөгийн хүчин зүйлсээс хамаарч Жолоочийн даатгалын нөөц санг эрсдэлгүй, найдвартай байршуулах үүднээс даатгалын сангийн хөрөнгөөс нөөц сан буй болгож дээрх 5 банкинд ижил тэнцүү хэмжээгээр хугацаатай хадгаламжийг байршуулдаг. 2015 онд хугацаатай хадгаламжийн хүү болох **631,008,300** төгрөгийн орлого жолоочийн даатгалын санд төвлөрсөн байна.

Шуурхай албаны дуудлагын үйлчилгээний орлого:

Аймаг, нийслэл дэх шуурхай албаны дуудлагын үйлчилгээний нийт орлого **7,365,440** төгрөгийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн.

Хүснэгт 18

Аймаг	Даатгалын тохиолдолын тоо	Шуурхай албаны дуудлагын орлого	Аймаг	Даатгалын тохиолдолын тоо	Шуурхай албаны дуудлагын орлого
Архангай	12	209,980	Сүхбаатар	3	50,820

Баян-Өлгий	6	101,640	Сэлэнгэ	10	169,040
Баянхонгор	0	0	Төв	8	135,520
Булган	15	255,460	Увс	10	169,400
Говь-Алтай	4	67,760	Ховд	4	67,760
Дорноговь	0	0	Хөвсгөл	14	237,160
Дорнод	8	135,520	Хэнтий	0	0
Дундговь	0	0	Дархан -Уул	54	926,800
Завхан	12	203,280	Орхон	173	2,859,220
Өвөрхангай	34	576,640	Говьсүмбэр	5	85,380
Өмнөговь	56	961,600	Холбооны ША	9	152,460
Нийт орлогын дүн					7,365,440

Гишүүний татвар, элсэлтийн хураамж орлого:

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 15 даатгагч гишүүдийн нэг жилийн татварын орлого нь тус бүр 1,000,000 төгрөгийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхээс 2015 онд гишүүдийн нийт татварын орлого 15,000,000 төгрөг санд төвлөрсөн байна.

2.2.2 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР

Жолоочийн даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөр олгох хүрээнд:

Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөрийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс хохирогчид олгож эхэлсэн ба 2013-2015 онд Жолоочийн даатгалын сангаас **124** хохирогчид нийт **305,253,596** төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.


Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн байдал, хэмжээ

Хүснэгт 19

№	Жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1	2013 он	2014 он	2015 он
1	Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан /18.1.1/	34,523,232	131,546,060	91,535,004
2	Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан/18.1.2/	6,020,900	19,178,900	22,449,500
3	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус/18.1.3/			
4	Даатгагч дампуурсан/18.1.4/			
5	Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл/18.1.5/			
	Нийт дүн	15 хүнд 40,544,132	60 хүнд 150,724,960	49 хүнд 113,984,504
		124 хүнд 305,253,596		

Жолоочийн даатгалын сан нь 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 58 өргөдөл, өмнөх оны 13 өргөдөл, нийт 71 нөхөн төлбөр хүссэн өргөдлийг хүлээн авсан. Үүнээс

- 2 ширхэг нь холбооны нийслэл дэх салбараас
- 69 ширхэг нь даатгалын компани болон бусад байгууллага, хувь хүмүүсээс тус тус хүлээн авч дараах байдлаар шийдвэрлээд байна.



Дээрх нөхөн төлбөрийг барагдуулнаас гадна дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

1. Зөвлөгөө өгч, хохирогч болон даатгалын тохиолдлын буруутай этгээдтэй Даатгалын сан нь хамтран ажилласны үр дүнд хоорондоо тохиролцон, 6 тохиолдолд буруутай этгээд нь хохирлоо 100 хувь буюу 5,277,352 төгрөгийг хариуцан барагдуулсан;
2. Даатгалын тохиолдолд холбогдогч талууд “жолоочийн даатгалын тухай” хуулийн 19.3-д заасан хугацаанд даатгалын санд хандаагүй, мөн хугацаанд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгоход шаардагдах бичиг баримтын бүрдүүлэлтийг хангаагүй, бүрдүүлж өгөөгүй зэрэг үндэслэлээр олгохоос татгалзсан 10 материал буюу 25,070,893 төгрөгийн хохирлыг барагдуулсан;



2015 оны 12 дүгээр сарын 31-ны байдлаар нийтдээ 157.384.749 төгрөгийн нөхөн төлбөр хүссэн өргөдөлийг хүлээн авснаас 113.984.504 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын сангаас олгож, 13.052.000 төгрөгийн өргөдлийн материал бүрдүүлэлтийн шатанд хянагдаж, 30.348.245 төгрөгийн өргөдлийг шийдвэрлэн холбогдох этгээдүүдэд албан ёсоор хариуг нь өгч ажиллаа.

Нөхөн төлбөр хүссэн 71 өргөдлийг ЖДТ хуулийн үндэслэлээр нь авч үзвэл:

- Хуулийн 18.1.1-ийг үндэслэж нэхэмжилсэн-57
- Хуулийн 18.1.2-ыг үндэслэж нэхэмжилсэн-9
- Хуулийн 18.1.3-ыг үндэслэж нэхэмжилсэн-1
- Хуулийн 18.1.5-г үндэслэж нэхэмжилсэн-4 байна.

Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийг бүрүүтэй этгээдээс буцаан нэхэмжлэсэн байдал

Холбоо нь 2013-2015 онд Жолоочийн даатгалын сангаас 124 хохирогчид нийт 305,253,596 төгрөгийн нөхөн төлбөрийг олгож буруутай этгээдтэй нь буцаан нэхэмжлэх гэрээг байгуулсан байна. Нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх гэрээг байгуулахдаа жолоочийн даатгалын тухай хууль, АЖДХ-ны гүйцэтгэх захирлын 2015 оны 01 сарын 30-ны өдрийн 02/06 тоот тушаалын хавсралт 1-6 –г удирдлага болгон ажилладаг.

2015 онд Жолоочийн даатгалын сангаас 49 хүнд нөхөн төлбөр олгосноос 42 хүний 39,170,064 төгрөгийг жолоочийн даатгалын санд буцаан төлсөн байна

Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн олголт, буцаан эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байдал

Хүснэгт 20

№	Он	Хүний тоо	Олгосон дүн	Хүний тоо	Хугацаа хэтэрсэн дүн
1	2013	15	40,544,132	7	15,533,160
2	2014	60	150,724,960	27	49,672,120
3	2015	49	113,984,504	7	12,656,450
Нийт дүн		124	305,253,596	41	77,861,730

Даатгалын сангаас олгож байгаа нөхөн төлбөрийн гэрээг хийхэд барьцаагүй ,хүүгүйгээр олгодог нь багагүй хүндрэлтэй байдал үүсгэж байна.

2.2.3 СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ХҮРЭЭНД

Албан журмын даатгагчдын холбооноос 2015 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, даатгуулагч, даатгалын төлөөлөгч, зуучлагч нарыг мэдээллээр хангах, тэднийг чадавхижуулахад чиглэгдсэн сургалт,

сурталчилгааны дараах ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

- Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж бууруулах зорилгоор “Монгол хүн-Монголын баялаг” 7 ширхэг видео сэрэмжлүүлгийг Холбооны веб сайт, facebook page болон youtube-д байршуулж, Нийслэлийн 9 дүүргийн засаг дарга нарт “Хамтран ажиллах тухай” албан бичгээр хүргүүлэв. Дүүргүүд эдгээр видео сэрэмжлүүлгийг иргэний танхим болон ЗДТГ-ын LED дэлгэцээр дамжуулан сурталчилж ард иргэдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажилд амжилттай хамтран ажиллаа.
- Олон нийтэд жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдол, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн телевизийн реклам, шторк, зөвлөгөө болон мэдээ мэдээллийн нэвтрүүлгийг хамтран бэлтгэх, нэвтрүүлэх зорилгоор ТВ8 телевизийн “Гарц” нэвтрүүлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллав. ТВ8 “Гарц” нэвтрүүлгийн бичлэгийг 7 хоног бүрийн бямба, ням гарагт давталттайгаар нийт 38 нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэлээ. Түүнчлэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг” ТББ-ын харьяа “Авторadio 96,3 FM-тэй хамтран ажиллаж 7 хоног бүрийн Баасан гарагт 14:00 -14:20 цагт “Жолоочийн даатгалын цаг” шууд нэвтрүүлэгт гишүүн даатгалын компаниудын даатгалын менежер, нөхөн төлбөрийн ажилтнууд оролцуулж зөвлөгөө өгч, сонсогчдын асуултад хариулт өгч ажиллалаа. Мөн хамтран ажиллах гэрээний дагуу “Монгол хүн- Монголын баялаг” зам тээврийн ослыг бууруулахад чиглэгдсэн агуулга бүхий 5 ширхэг FM шторк /хамгаалах бүс, согтууруулах ундаанаас татгалзах, хариуцлагыг чангатгая, жолооны ард гар утас хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэхгүй байх/ захиалж хийлгэв. Уг FM шторкийг орон нутгийн FM, “Авторadio 96,3” FM-ээр гэрээнд заасан давтамжтайгаар цацаж иргэд олон нийтэд хүргэсэн.
- МҮОНР радиогийн автомашин эзэмшигчдэд зориулсан 7 хоног тутмын “Авторadio сонин” мэдээллийн хөтөлбөрт 20 минутын хугацаатай “Хариуцлагын даатгал таныг хамгаална” сэдэвт сурвалжилсан тэмдэглэлийг 10,11,12-р сард нийт 5 дугаарт, “Тэнхлэг” мягмар гарагийн шууд хөтөлбөрийн “Та замд явна уу?” нэвтрүүлэгт АЖДХ-оос оролцож, жолооч, тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэдтэй ярилцах 20 минутын хугацаатай ярилцлагыг 10,11, 12-р сард нийт 5 дугаарт оруулж Жолоочийн хариуцлагын даатгалын тухай сурвалжлага, ярилцлага, уран сайхны нэвтрүүлэг нийт 10 дугаарыг эрхэлж, сонсогчдод хүргэлээ. МҮОНР радиогийн “Тэнхлэг” шууд хөтөлбөрийн “Та замд явна уу?” ярилцлагад оролцов.
- МҮОНР радиогийн “Гурван-Эрдэнэ” студитэй хамтран Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт аймаг, орон нутаг, улсын хэмжээнд ямар байгаа, тээврийн хэрэгсэл эзэмшигчид юуг анхаарах, хуулийн хэрэгжилтийг хангах мэргэжлийн байгууллагуудын оролцоо, үүрэг ямар байгааг тайлбарлан таниулж тулгамдсан асуудлуудад хариулт өгөх зорилго бүхий радио нэвтрүүлгийг 10-12 дугаар сард тус бүр 2 дугаар, нийт 6 дугаарыг тус бүр нь 20 минутын үргэлжлэх хугацаатайгаар 12 цацалттайгаар гаргаж иргэд, олон нийтэд сонордуулав.
- МҮОНР “Авторadio сонин” шууд нэвтрүүлэг болон МҮОНРТВ-ийн ММ агентлагийн “Цагийн хүрд” нэвтрүүлэг, РЗ радио FM 100,9-ийн “Хууль бидний амьдралд” шууд нэвтрүүлэгт оролцож дээрх нэвтрүүлгүүдийн бичлэгийг Холбооны вебсайтад тухай бүр байрлуулав.
- ЗЦГ-тай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол,

хэргийг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Замын хөдөлгөөний хууль дүрмийн мэдлэгийг сайжруулах, хөдөлгөөнд аюулгүй, соёлтой оролцох дадлыг зөв хэвшүүлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээллийг хүргэх зорилгоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах” сэдэвт шторк, дэлгэцийн богино хэмжээний бүтээлийн уралдааныг байгууллага, ард иргэдийн дунд зарлаж дүгнэсэн. Уралдаанд шалгарсан бүтээлүүдийг Холбооны facebook хуудсанд байршуулж social media сурталчилгаанд ашиглаж байна. ТВ-ээр цацаж олон нийтэд санамж, сэрэмжлүүлэг хүргэх ажлыг хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд ЗЦГ хариуцахаар тогтсон.

- “Маш чухал мэдээ”ХМХ, YIP сэтгүүл, веб сайт-тай www.vip76.mn портал сайтаар дамжуулан Албан журмын даатгагчдын холбооны мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, профайл хуудсанд мэдээ, мэдээлэл байршуулах, онлайн хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор хамтран ажиллах тухай гэрээ байгуулсан. Энэ дагуу АЖДХ-ны Гүйцэтгэх захирал Б.Нямдорж тус сэтгүүлд ярилцлага өгсөн.
- Монголын даатгагчдын холбооноос эрхлэн явуулдаг даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалтад 3 удаа оролцож ердийн даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт, Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос хохирол үнэлэгчдийг бэлтгэх, тэднийг чадавхижуулах зорилгоор зохион байгуулсан 3 удаагийн сургалтыг “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал” сэдвээр нийт 151 хүнд хичээл заасан.
- СЗХ-ны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 303 дугаар тогтоол “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх” журам, 304 дүгээр тогтоол “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх” журам, 305 дугаар тогтоол “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний даатгуулагчийн мэдүүлгийн маягт”-д орсон өөрчлөлтүүдийн талаар даатгагч, зуучлагч нарт сургалт явуулах хөтөлбөрийг боловсруулж, “Жолоочийн даатгалын хураамж тооцох итгэлцүүрийн журамд орсон өөрчлөлт” сэдвээр даатгалын компаниудын албан журмын даатгал хариуцсан захирал, ахлах ажилтнуудад, зуучлагч болон ажлын албан ажилтнуудад сургалт явуулсан. Монголын даатгалын зуучлагчдын холбооны хүсэлтийн дагуу FM-107,5 радиогоор “Жолоочийн даатгалын хураамж тооцох итгэлцүүрийн журамд орсон өөрчлөлт” сэдвээр 30 минутын хичээл заасан. “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай СЗХ-ны 2015 оны 6 дугаар сарын 10-ны 274 дүгээр тогтоол, “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 6.2-т орсон нэмэлт өөрчлөлт жолоочийн даатгалын итгэлцүүрийн тухай зэрэг даатгалын мэргэжлийн оролцогчдын зүгээс ирүүлсэн асуултад хариулт, дэлгэрэнгүй тайлбар, тодруулга мэдээлэл өгсөн байна.
- “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гарын авлага” 1000 ширхэг; брошур 10,000 ширхэгийг тус тус хэвлүүлж орон нутаг дахь салбараар дамжуулан сурталчилж байна.
- Монголын даатгагчдын холбооноос эрхлэн явуулдаг даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалтад 3 удаа оролцож, ердийн даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт, Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос хохирол үнэлэгчдийг бэлтгэх, тэднийг чадавхижуулах зорилгоор зохион байгуулсан 3 удаагийн сургалтад “Жолоочийн

хариуцлагын албан журмын даатгал” сэдвээр нийт 151 хүнд хичээл заасан.

- “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гарын авлага” 1000 ширхэг; брошур 10,000 ширхэгийг тус тус хэвлүүлж орон нутаг дахь салбараар дамжуулан сурталчилж байна.

2.3 ШУУРХАЙ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.3.1 ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Холбооны шуурхай албаны 70101177 дугаарын телефон утсанд ирсэн 1323 мэдээллийг хүлээн авч бүртгэсний дотор, даатгалын тохиолдлын /сангийн/ дуудлага 4, хууль тогтоомжийн лавлагаа 100, Мэдээллийн сангийн лавлагаа 409, нөхөн төлбөрийн лавлагаа 75, даатгалын сангийн лавлагаа 73, санал хүсэлт 58, Даатгалын компаний утас, байршлын лавлагаа 105, бусад мэдээлэл 503 байлаа.

Тус шуурхай алба 2015 оны 10 дугаар сарын 01-ээс 24 цагийн ээлжийн горимоор ажиллах болсон. 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Миг даатгал, Мандал даатгал, Мөнх даатгал компаниудтай шуурхай албаны үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

2015 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар шуурхай албанд даатгалын тохиолдлын 19 дуудлага хүлээн авч дуудлагын дагуу зам тээврийн осол болсон газарт цаг алдалгүй шуурхай очиж, даатгалын тохиолдлын газрын үзлэг хийн материал бүрдүүлэн Даатгалын компаниудын нөхөн төлбөрийн мэргэжилтэнд зохих журмаар шилжүүлэн өгөв.

2.3.2 ХАМТАРСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.1-5.3, 8.2 заалтын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Замын цагдаагийн албатай хамтран улсын хэмжээнд 1, нийслэлийн хэмжээнд 2 удаа нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, уг хамтарсан шалгалтанд даатгалын зуучлагч компаниудыг оролцуулж даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож явсан жолооч нарын зөрчлийг газар дээр нь ажилгаж жолоочийн даатгалд хамруулж ажиллав.

Шалгалтын явцад нийт 21137 тээврийн хэрэгслэл шалгаснаас 4261 зөрчил илрүүлсний дотор жолоочийн даатгалд хамрагдаагүй 747/ аж ахуйн нэгжийн өмчлөлийн тээврийн хэрэгсэл жолоодож яваа жолооч мэргэшсэн жолоочийн даатгалд хамрагдаагүй ороод/, даатгалын гэрээний хугацаа дууссан 2691, амины тээврийн хэрэгслийг өмчлөгчийн даатгалын гэрээнд нэр бичигдээгүй хүн жолоодож явсан 716 зэрэг зөрчил илрүүлсэн байна.

Илэрсэн дээрх зөрчлөөс газар дээр нь 2663-ийг арилгасан буюу жолоочийн даатгалд хамруулан даатгалын гэрээ байгуулж өгсний гадна өөрийн өмчлөлийн автомашиндаа даатгалтай боловч бусдын автомашины даатгалын гэрээнд нэр бичигдээгүй/мэргэшсэн жолоочийнхоос бусад/ хүн жолоодож явсан 678 тохиолдлыг сануулан, даатгалгүй болон даатгалын хугацаа дууссан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож явсан 452 зөрчилд

Жолоочийн даатгалын тухай хуулийн 28.1.1-д заасны дагуу тус бүрд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний буюу 192000 төгрөгөөр, нийт 87.552.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

3.1. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Холбоо нь 2015 онд дотоод үйл ажиллагааны чиглэлээр хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг төлөвлөн зохион байгуулж, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн бүх салбарын 32 ажилтнуудын зөвлөлгөөнийг 2 удаа зохион байгуулж ажилласан.

2015 онд Гүйцэтгэх захирал нийт 201 тушаал гаргаж ажлын албаны үйл ажиллагааг чиглүүлэн ажиллажээ. Холбоонд байгууллага, иргэдээс 358 албан бичиг, өргөдөл гомдол ирсэн ба даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөр олгохтой холбогдол бүхий 35, хүний нөөцийн чиглэлээр 99, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 102 тушаал баталсан байна. Харилцагч байгууллагуудад 719 албан бичиг илгээж, үүнээс 33 хариутай бичигт хариу авч шийдвэрлэсэн байна.

3.2. ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВАР БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2015 онд Албан журмын даатгагчдын холбооны хөдөлмөрийн дотоод журам, Албан журмын даатгагчдын холбооны нууцыг хадгалах, хамгаалах журам, удирдлагын зөвлөлийн хуралдааны дэг зэргийг шинэчлэн батлав.

Албан журмын даатгалтай холбогдол бүхий эрх зүйн мэдээллийн е-санг бий болгох бэлтгэл ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, эрхийн актыг системчлэх ажил хийгдэж байна.

Албан журмын даатгалын холбооны дүрэм, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам, Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газарт Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн хариуцлагын даатгалын МИИС системээр дамжуулан цахим хэлбэрээр гэрээний мэдээллийг солилцоход бүрэн боломжтой болсон тул даатгалын баталгааны хэвлэмэл хэлбэрийг хүчингүй болгохоор санал оруулж, СЗХорооны дарга, Хууль зүйн сайдын хамтарсан 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 73/А/66 дугаар тушаалаар баталгааны журмыг шинэчлэн батлуулж шийдвэрлүүлсэн.

3.3. ХОЛБООНЫ 2015 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Холбооны Удирдах зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоол, 2015 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 2015 оны төсвийг зардлын ангилал бүрээр баталсан. Холбооны 2015 оны үндсэн үйл ажиллагааны зардалд 1,172,248.7 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 165,000.0 мянган төгрөг төсөвлөн баталсан. Үндсэн үйл ажиллагааны зардлыг 66,966.6 мянган төгрөгөөр хэмнэж 1,105,282.1 мянган төгрөгийг хууль, журамд заасны дагуу зарцуулсан.

Холбооны 2015 оны зардлын гүйцэтгэлийг доорх хүснэгтээр дэлгэрнгүй танилцууллаа.

Хүснэгт №2. Холбооны зардлын гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Хүснэгт 21

2015.12.31

Д/д	Зардлын төрөл	Гүйцэтгэл			2015 он	
		2012	2013	2014	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ						
1.1	Ажлын албаны ажилтнуудын цалин хөлс, урамшуулал	167,014.3	298,502.2	488,431.8	600,174.3	598,886.7
1.2	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	17,836.5	31,305.2	51,350.8	66,019.2	61,890.4
1.3	Удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн урамшуулал, нэмэгдэл	26,600.0	17,254.7	24,976.9	31,800.0	32,100.0
1.4	Албан томилолтын зардал	9,539.6	12,035.1	29,294.1	25,000.0	16,937.3
1.5	<i>Захиргаа, аж ахуйн зардал</i>	<i>17,460.2</i>	<i>15,426.0</i>	<i>19,317.2</i>	<i>30,000.0</i>	<i>23,858.1</i>
Үүнээс:	Аж ахуйн зардал	6,586.7	11,088.4	731.9	2,800.0	2,630.8
	Бичиг хэргийн зардал	3,681.9	4,337.6	10,880.0	7,200.0	7,886.1
	Даатгал, оношлогоо, татвар, аудит	7,191.6	-	7,705.3	20,000.0	13,341.2
1.6	Ажлын байр, гражийн түрээсийн зардал	20,829.5	157,523.5	186,345.9	200,620.8	210,086.8
1.7	Автомашинны шатахуун, сэлбэг, засварын зардал	10,039.7	11,674.9	52,246.3	43,200.0	34,844.7
1.8	Харилцаа, холбооны зардал	7,487.7	15,981.5	27,643.6	30,000.0	27,526.3
1.9	Даатгалын тохиолдлыг бууруулахад чиглэсэн сурталчилгааг санхүүжүүлэх	21,348.2	67,075.6	73,178.4	90,354.4	73,096.1
1.10	Хариуцлагын даатгалын талаарх семинар, зөвлөгөөн зохион байгуулах	153.1	8,218.4	5,711.0	17,000.0	10,177.6

1.11	Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирол үнэлгээний зардал	-	598.0	3,374.3	6,000.0	1,744.5
1.12	Орон нутгийн салбаруудын урсгал зардал	-	6,480.3	-	32,080.0	14,133.7
	Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн	298,308.8	642,075.4	961,870.3	1,172,248.7	1,105,282.1
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ						
2.1	Тавилга, техник хэрэгсэл	26,701.9	55,245.9	35,942.7	15,000.0	15,218.5
2.2	Мэдээллийн сангийн програм хангамж, хөгжүүлэлтийн зардал	10,200.0	140,264.2	79,955.0	140,000.0	12,042.4
2.3	Ажлын алба, шуурхай албадын автомашин худалдан авалт	-	190,000.0	338,320.0	-	-
2.4	Санхүүгийн програм хангамж, аюулгүй байдлын зардал	-	-	-	10,000.0	1,956.0
2.5	Сургалтын техник, тоног төхөөрөмж	-	19,000.0	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардлын дүн	36,901.9	404,510.1	454,217.7	165,000.0	29,216.9
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	335,210.7	1,046,585.5	1,416,088.0	1,337,248.7	1,134,499.0

Холбооны нийт хөрөнгө 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7,478,380.6 мянган төгрөг, үүнээс 90,6 хувь буюу 6,772,654.6 төгрөг нь эргэлтийн хөрөнгөөр, 9,4 хувь буюу 705,726.1 мянган төгрөг нь эргэлтийн бус хөрөнгөөр байршиж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ САНАЛ

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоо нэвтэрснээр тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, даатгалтай эсэхээс үл хамааран авто замын осолд өртсөн гуравдагч этгээд буюу эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагад нөхөн төлбөр олгож, хариуцлагын даатгалын ач холбогдлыг иргэд ойлгодог болж байна.

Хэдийгээр 2015 онд багагүй ажлыг амжуулсан боловч, цаашид анхаарах, яаравчлан шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байсаар байна. Үүнд:

Холбооны үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчинг зохих судалгаа, шинжилгээний дүнд сайжруулах зайлшгүй шаардлага байгааг анхааралдаа авч, 2016 онд бодлогын чанартай, тухайлбал Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн уялдаа холбоог хангах чиглэлээр тодорхой асуудлуудыг боловсруулж, холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

4.1 ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг УИХ-аас баталсан хуваарьт хугацаанд төвлөрүүлдэг болгох шаардлагатай байна. Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013 оны 20/19 тоот хамтарсан тушаалаар “Жолоочийн даатгалын сангийн дансанд хөрөнгө шилжүүлэх тухай” журмыг баталсан. Энэ журмын дагуу Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нар аймаг, нийслэлийн төсвийн хуваарьт тусгагдсан эх үүсвэрийн гүйцэтгэлийг сар тутам тооцож, дараа сарын 10-ны өдрийн дотор “Албан журмын даатгагчдын холбооны жолоочийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансанд шилжүүлнэ” гэж заасан боловч УИХ-аас баталсан хуваарийг орон нутаг дахь ИТХ нь дур мэдэн хасаж батлах, хугацаандаа төвлөрүүлэхгүй байх хүндрэлүүд гарсаар байна. Даатгалын санд төвлөрч буй орлогыг тухайн орон нутагт нь зарцуулж байгаа бөгөөд төвлөрүүлбэл зохих орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэхгүй байгаа нь даатгалын тохиолдлын улмаас хохирсон иргэдэд нөхөн төлбөрийг хугацаанд нь олгох боломжгүй болох зэрэг эрсдэл бий болох магадлалтай юм.

Сангийн яамнаас хязгаарласан, хассан, данс нээхгүй байна, эрх өгөхгүй гэх мэт шалтгаанаас болж энэ жилийн АТБӨЯХАТ-ын 10 хувийн орлого 56 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Нийслэлээс АТБӨЯХАТ-ын гүйцэтгэлийн 10 хувийг жолоочийн даатгалын санд дутуушилжүүлснээс орлогын төлөвлөгөө тасарсан байна. Иймээс УИХ-аас батлагдсан хэмжээгээр жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлж байх, төвлөрүүлээгүй бол Сангийн сайд, Зам тээврийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 20/19 дүгээр тушаалын хавсралт “Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх журам”-ын ГУРАВ-ыг удирдлага болгон ажиллах шаардлагатай байна. зохих арга хэмжээ авах тухай журмыг Санхүүгийн зохицуулах хороо шийдвэрлэх нь зүйтэй юм.

Мөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглагдах ёстой “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 28.1-т заасан торгуулийн 50 хувийн орлого

жолоочийн даатгалын санд төвлөрөхгүй байна Энэ орлогыг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байгаа боловч төсөвт суулгаж батлагдаагүй гэсэн шалтгаанаар нийслэл болон орон нутгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн олонхи нь хэрэгжүүлэхгүй байна. Дээрх асуудлуудыг шийдвэрлүүлэх асуудлаар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

4.2 МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Даатгалын компанийн төлөөлөгч, зуучлагчид даатгалын гэрээг цахим байдлаар хийж баталгаажуулах болон нөхөн төлбөр өгөх тохиолдол бүрийг мэдээллийн нэгдсэн санд шууд орж байхаар програм боловсруулагдсан боловч тус програмыг ашиглах төлөөлөгч, даатгагч, зуучлагч нар холбогдох журам зааврын талаар бүрэн мэдлэггүй, мэдлэгтэй ажилтан нар нь хурдан солигдож байдаг нь журмын хэрэгжилтэнд хүндрэл учруулж байна. Журам хэрэгжүүлэх, программыг зөв ашиглах талаар сургалт явуулж шалган тэнцсэн хүмүүсд эрх олгох нь даатгалын компани, зуучлагч нар хүний нөөцийн хувьд тогтвортой, хууль журмыг таниулах, зөв хэрэглэх мэдлэг чадвартай боловсон хүчинтэй байх үндэс суурь болох юм. Иймээс тус сургалтыг явуулан эрх олгох саналтай байна.

Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилийн хангах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлхийн тулд мэдээллийн хүчирхэг бааз санг бий болгох, мэдээллийн чанарт онцгой анхаарах, холбогдох байгууллагатай сүлжээгээр холбогдох шаардлагатай байна. Үүний тулд мэдээллийн сангийн програм хангамж, сүлжээг шаардлагын түвшинд хүртэл яаралтай хөгжүүлэх, холболт хийх түүнд зориулж тодорхой төсөл боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ асуудлыг зөвхөн Холбооны түвшинд бус Засгийн газрын түвшинд танилцуулах, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Энэ чиглэлээр ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

Аль ч салбарын үйл ажиллагааг оновчтой удирдахад цаг үеийн үнэн зөв мэдээлэл чухал үүрэгтэй. Гэтэл даатгалын компаниудад жолоочийн даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олголт зэргээс үзэхэд дэндүү хайхрамжгүй хандаж байгааг олон баримтаар нотолж болох байна. Төр, засгаас жолоочийн даатгалын тухай хуулийг баталж хэрэгжүүлсэн нь нийгэмд бий болсон сахилгагүй, хариуцлагагүй байдлыг арилгах, зам, тээврийн ослын улмаас учруулсан амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохиролыг нимгэлэхэд чиглэсэн арга хэмжээний нэг хэсэг мөн. Иймээс даатгалын компаниудын жолоочийн хариуцлагын даатгал хийх чадамжыг сайжруулах, зах зээлийн замаар нь явуулах талаар эргэн авч үзэх шаардлагатай байна. Энэ байдлыг даатгалын үйлчилгээ жигд биш, ялангуяа орон нутагт (нийслэлээс бусад), даатгалын гэрээний болон нөхөн төлбөрийн мэдээллийг цаг тухай бүр мэдээллийн санд оруулдаггүй, даатгалын статистик мэдээ тайлан гаргахад хэт хайхрамжгүй хандах зэрэг дутагдал нийтлэг байгаагаас харж болно.

4.3 ШУУРХАЙ АЛБАНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Санхүүгийн зохицуулах хороо баталсан “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам” нь даатгалын тохиолдлуудын өчүүхэн бага хэсэгт буюу зөвхөн тус Холбооны шуурхай албанд даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа дууссан, даатгагч нь дампуурсан этгээд даатгалын тохиолдол гаргасан болон даатгалын тохиолдол

гаргасан этгээд тодорхойгүй тохиолдолд л дагаж мөрдөхөөр зохицуулагдсан байгаа бөгөөд дийлэнх олонхид буюу жолоочийн даатгалын ихэнх тохиолдолд нэгдсэн журам үгүйлэгдэж байгаа юм.

Хорооны 2015 оны 01 сарын 21-ний өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан дээрх журмын 6-аас бусад заалт нь жолоочийн даатгалын шуурхай албаны нийтлэг шаардлагад нийцсэн, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шуурхай албанд заавал дагаж мөрдүүлэх заалтууд байх тул Холбооны гишүүд даатгалын компанийн болон тэдэнд үйлчилдэг бусад шуурхай албанд багаж мөрдөх боломжтой гэж үзэж байна. Иймд: Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам”-ын 1.1, 2.2, 2.3-ын “...Шуурхай алба нь Холбооны бүтцэд байх бөгөөд түүний бүрэлдэхүүн, орон тоо,” гэснээс, 2.7, 6.1, 6.2-оос бусад заалтыг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа даатгалын компанийн болон тэдэнд үйлчилж байгаа шуурхай албанд дагаж мөрдүүлэх саналтай байна.

--000--